

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 11 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 261

Улаанбаатар хот

“УБ транс” ХХК-иас нийтэд санал болгон
гаргах үнэт цаасыг бүртгэхээс татгалзах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.10.1 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх журам”-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “УБ транс” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй 500 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 6 086 847 ширхэг энгийн хувьцааг бүртгэхээс татгалзсугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ